

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025.03.31

Улаанбаатар хот

Хурал 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10:00 цагт “Хөнгөн бетон” ХК-ийн хурлын өрөөнд 10:00-10:15 цагт хуралдав.

Хурлын дарга Б.Наранзул хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав. Үүнд:
“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179,373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177,154 ширхэг байгаа ба 98.76%-ийн ирцтэй байгаа тул хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэв.

Хурлын ирц:

1. Б.Наранзул – 130,958 ширхэг хувьцаа эзэмшдэг
2. Б.Наранцацралт – 30,244 ширхэг хувьцаа эзэмшдэг
3. Минжит булган гол ХХК /Гүйцэтгэх захирал/ - 14,918 ширхэг хувьцаа эзэмшдэг
4. Т.Баярхүү /өв залгамжлагч Б.Наранзул, Б.Наранцацралт/ - 1,034 ширхэг хувьцаа эзэмшдэг

Хурлын дарга Б.Наранзул хурлыг нээж үг хэлэв.

- “Хөнгөн бетон” ХК-ийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье. Эхний ээлжинд хурлын дэг, дарааллыг танилцуулъя.
- Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрийг нь хэлэлцээд асуудал тус бүрээр нь саналыг аваад шийдвэрлээд явах саналтай байна. Үүнтэй санал нэг байна уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар хурлын дэг, дарааллыг батлав.

Асуудал 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах.

- Хурлын дарга Б.Наранзул: 2024 оны компанийн үйл ажиллагааны тайланг уншиж танилцуулав.
- 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №01 тоот “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах” тогтоолын төслийг танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

Асуудал 2. Ногдол ашиг хуваарьлахгүй талаар

- Хурлын дарга Б.Наранзул: ХАС банкны хамтарсан зээлээр аливаа өр зээлийг төлж барагдуулах хүртэл ногдол ашгийг хуваарилж төлөхгүй гэсэн зээлийн гэрээний үүрэг хүлээсэн учир ногдол ашиг хуваарилах боломжгүй бөгөөд компани үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон байгаа.
- Цаашид ч ногдол ашиг хуваарилахгүй байх талаар саналаа хураая. Гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг зөвшөөрч байна уу?

- 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын №02 тоот “Компанийн 2024 оны ногдол ашгийн тухай” тогтоолын төслийг хамтад нь танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.

- Хурлын дарга Б.Наранзул: Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэсэн дүнгээ гаргаад саналын тоог танилцуулаарай.
- Тооллогын комиссийн дарга Б.Батбаяр: Саналын хуудсыг нэгтгэн тооллоо. Үүнд:

- 1). “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах” талаар саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн байна.
- 2). “Компанийн 2024 оны ногдол ашгийн тухай” талаар саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид 100% зөвшөөрсөн байна.



Хурлын дарга Б.Наранзул: За ингээд хэлэлцэх асуудал дууссан тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн: Хурлын нарийн бичгийн дарга:



А.ЧАНЦАЛДУЛАМ

Хурлын тэмдэглэлтэй танилцсан Хувьцаа эзэмшигчид:

1.  Б.Наранзул
2.  Б.Наранцацралт
3.  Минжит булган гол ХХК-г төлөөлж Б.Наранзул
4.  Б.Наранзул / Т.Баярхүү нас барсан тул өв залгамжлагч/
-  Б.Наранцацралт / Т.Баярхүү нас барсан тул өв залгамжлагч/

